



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 117
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 10,773,819.40 (арван сая долоон зуун далан гурван мянга найман зуун арван есөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 117 дугаар сургууль (Х.Барнам)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй нийт 1080 ширхэг 2,097,800.00 (хоёр сая ерэн долоон мянга найман зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 117 дугаар сургууль (Х.Барнам)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

В.ОЮУМАА

Эсгэлийн Өмчийн харилцааны газрын
2024 оны 1-дугаар сарын 4-ний
дүрлийн 487-дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 117 дугаар сургууль

[illegible]